

УУЛ УУРХАЙН САЛБАРЫН 2019 ОНЫ 2 САРЫН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

II. УУЛ УУРХАЙН САЛБАРААС УЛСЫН ТӨСӨВТ ОРУУЛСАН ТАТВАР, ХУРААМЖ

2018 оны жилийн эцсийн байдлаар улсын төсөвт 2,051.5 тэрбум төгрөг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Үүнээс:

- Алт 80.0 тэрбум төгрөг,
- Нүүрс 910.6 тэрбум төгрөг,
- Цайр 76.9 тэрбум төгрөг,
- Зэс 871.9 тэрбум төгрөг,
- Төмөр 17.1 тэрбум төгрөг,
- Жонш 16.3 тэрбум төгрөг,
- Бусад 78.8 тэрбум төгрөг,

Улсын төсөвт орсон орлогыг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 456.3 тэрбум төгрөг буюу 28.6 хувиар өссөн. Үүнээс:

- Алт 31.0 (63.1%) тэрбум төгрөг,
- Нүүрс 306.8 (50.8%) тэрбум төгрөг,
- Цайр 13.6 (21.5%) тэрбум төгрөг,
- Зэс 71.1 (8.9%) тэрбум төгрөг,
- Төмөр 4.7 (38.6%) тэрбум төгрөг,
- Жонш 4.0 (32.1%) тэрбум төгрөг,
- Бусад 25.0 (46.5%) тэрбум төгрөг.

2019 оны 2 дугаар сарын байдлаар улсын төсөвт **478.0** тэрбум төгрөг татвар, хураамж хэлбэрээр төвлөрүүлсэн байна. Үүнээс:

- Алт **5.1** тэрбум төгрөг,
- Нүүрс **184.2** тэрбум төгрөг,
- Цайр **11.5** тэрбум төгрөг,
- Зэс **259.8** тэрбум төгрөг,
- Төмөр **4.3** тэрбум төгрөг,
- Жонш **3.3** тэрбум төгрөг,
- Бусад **9.7** тэрбум төгрөг,

Улсын төсөвт оруулсан орлого өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад **124.3** тэрбум төгрөг буюу **35.1** хувиар өссөн. Үүнээс:

- Алт **1.2 (32.0%)** тэрбум төгрөг,
- Нүүрс **62.5 (51.4)** тэрбум төгрөг,
- Зэс **67.6 (35.2)** тэрбум төгрөг,
- Жонш **1.2 (59.3%)** тэрбум төгрөг,

Харин

- Цайр **4.9 (29.9%)** тэрбум төгрөг,
- Төмөр **1.2 (22.1%)** тэрбум төгрөг,
- Бусад ашигт малтмал **2.1 (18.2%)** тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Улсын төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамж, ашигт малтмалаар

тэрбум төгрөг

Үзүүлэлт	2018			2019 I			Өөрчлөлт					
	I	II	Нийт	I	II	Нийт	(5-2)=?, (5/2)=%	(6-3)=?, (6/3)=%	(7-3)=?, (7/3)=%			
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
Нийт дүн	185.2	168.6	353.7	326.2	151.8	478.0	141.0	76.2%	-16.7	-9.9%	124.3	35.1%
Алт	2.4	1.4	3.9	3.4	1.7	5.1	1.0	39.7%	0.3	19.0%	1.2	32.0%
Нүүрс	57.3	64.4	121.7	139.8	44.5	184.2	82.5	144.0%	-19.9	-31.0%	62.5	51.4%
Цайр	4.7	11.8	16.5	5.0	6.5	11.5	0.4	8.1%	-5.3	-44.9%	-4.9	-29.9%
Зэс	112.3	79.9	192.2	168.1	91.7	259.8	55.8	49.7%	11.8	14.8%	67.6	35.2%
Төмөр	0.3	5.3	5.6	2.2	2.2	4.3	1.9	627.9%	-3.1	-58.7%	-1.2	-22.1%
Жонш	1.3	0.8	2.1	2.2	1.1	3.3	0.9	71.1%	0.3	39.8%	1.2	59.3%
Бусад	6.9	5.0	11.8	5.5	4.2	9.7	-1.4	-20.2%	-0.8	-15.3%	-2.1	-18.2%

Улсын төсөвт төвлөрүүлсэн татвар, хураамжийн мэдээлэл, татварын төрлөөр

тэрбум төгрөг

Үзүүлэлт	2018			2019 I			Өөрчлөлт					
	I	II	Нийт	I	II	Нийт	(5-2)=?, (5/2)=%	(6-3)=?, (6/3)=%	(7-3)=?, (7/3)=%			
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
Нийт дүн	185.2	168.6	353.7	326.2	151.8	478.0	141.0	76.2%	-16.7	-9.9%	124.3	35.1%
Агаарын бохирдлын төлбөр	4.3	2.2	6.5	6.7	0.5	7.1	2.4	54.6%	-1.7	-79.4%	0.6	9.7%
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	42.1	62.0	104.1	54.3	88.0	142.2	12.1	28.8%	26.0	42.0%	38.2	36.7%
Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	62.4	25.4	87.8	123.0	14.3	137.3	60.6	97.1%	-11.1	-43.8%	49.5	56.3%
Газрын төлбөр	0.9	1.1	2.0	1.3	0.7	2.0	0.4	41.4%	-0.4	-36.1%	-0.04	-1.8%
Дотоодын бараа, үйлчилгээний НӨАТ	2.2	5.3	7.5	2.8	1.7	4.5	0.6	25.9%	-3.6	-68.5%	-3.1	-40.7%
Хувь хүний орлогын албан татвар /суутгагчийн/	6.3	9.1	15.4	6.1	13.1	19.2	-0.2	-3.3%	4.0	44.0%	3.8	24.6%
Өсөн нэмэгдэх АМНАТ	50.3	51.1	101.4	120.2	13.5	133.7	69.9	139.1%	-37.6	-73.6%	32.3	31.9%
Үл хөдлөх хөрөнгийн татвар	0.6	0.8	1.5	0.0	1.7	1.7	-0.6	-99.9%	0.8	98.5%	0.2	13.8%
Ус, рашаан ашигласны төлбөр	2.7	2.3	4.9	1.8	3.8	5.6	-0.9	-33.6%	1.6	67.8%	0.7	13.4%
Бусад	13.3	9.2	22.5	10.1	14.6	24.7	-3.2	-24.3%	5.4	58.4%	2.1	9.5%

II. АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

II.1. Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл

2019 оны 2 дугаар сард **8.0** сая тн нүүрс, **239.1** мян.тн зэсийн баяжмал, **856.2** кг алт, **817.0** тн молибдений баяжмал, **383.3** мян.тн төмрийн хүдрийн баяжмал, **1.3** мян.тн хайлуур жоншны баяжмал, **15.9** мян.тн цайрын баяжмал, **1.1** сая тн бар газрын тос үйлдвэрлэсэн байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нүүрс **1.5** сая тн буюу **23.1** хувь, зэсийн баяжмал **30.9** мян.тн буюу **14.8** хувь, төмрийн хүдрийн баяжмал **32.6** мян.тн буюу **9.3** хувь, цайрын баяжмал **1.0** мян.тн буюу **6.7** хувиар ихээр тус тус өссөн байна.

Харин алт **419.8** кг буюу **32.9** хувь, молибдены баяжмал **33.8** тн буюу **4.0** хувь, хайлуур жоншны баяжмал **0.7** мян.тн буюу **35** хувь, газрын тос **75.6** мян.бар буюу **6.4** хувь, катодын зэс **85.1** тн буюу **3.6** хувиар тус тус буурсан байна.

№	Бүтээгдэхүүний төрөл	Хэмжих нэгж	2018		2019		Өөрчлөлт			
			II	I-II	II	I-II	(5-3)=?, (5/3)=%	(6-4)=?, (6/4)=%		
	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Уул уурхай, олборлох аж үйлдвэр									
1.1	Нүүрс	мян.тн	2,669.8	6,497.8	3,863.2	8,000.3	1,193.4	44.7%	1,502.5	23.1%
1.2	Газрын тос	мян.бар	556.5	1,177.4	515.4	1,101.8	-41.1	-7.4%	-75.6	-6.4%
1.3	Зэсийн баяжмал, м/агуулгаараа	мян.тн	109.2	208.2	111.1	239.1	1.9	1.7%	30.9	14.8%
1.4	Молибдений баяжмал, м/ агуулгаараа	тн	419.0	850.8	415.9	817.0	-3.1	-0.7%	-33.8	-4.0%
1.5	Алт	кг	458.0	1,276.0	252.9	856.2	205.1	-44.8%	-419.8	-32.9%
1.6	Төмөр:									
	- Төмрийн хүдрийн олборлолт	мян.тн	334.0	795.4	306.2	521.8	-27.8	-8.3%	-273.6	-34.4%
	- Төмрийн хүдрийн баяжмал	мян.тн	157.9	350.7	241.2	383.3	83.3	52.8%	32.6	9.3%
1.7	Хайлуур жонш:									
	- Хайлуур жонш	мян.тн	9.2	19.1	7.0	16.5	-2.2	-23.9%	-2.6	-13.6%
	- Хайлуур жоншны баяжмал	мян.тн	1.6	2.0	-	1.3	-1.6	-100.0%	-0.7	-35.0%
1.8	Цайрын баяжмал	мян.тн	6.6	14.9	8.3	15.9	1.7	25.8%	1.0	6.7%
2	Боловсруулах аж үйлдвэр									
2.1	Катодын зэс, 99%	тн	1,080.2	2,342.5	1,020.9	2,257.4	-59.3	-5.5%	-85.1	-3.6%
2.2	Металл бэлдэц	тн	1,701.6	4,429.8	3,676.9	7,197.5	1,975.3	116.1%	2,767.7	62.5%
2.3	Металл цувимал	тн	2,424.3	3,813.5	3,932.0	7,556.9	1,507.7	62.2%	3,743.4	98.2%

Эх сурвалж: ҮСХ

II.2. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэл

тэрбум төгрөг

Салбар	2018		2019		Өөрчлөлт			
	II	I-II	II	I-II	(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9
Нийт дүн	956.1	2,070.7	1,175.3	2,471.0	219.3	22.9%	400.3	19.3%
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	673.4	1,471.9	856.1	1,803.8	182.7	27.1%	331.9	22.5%
Нүүрс олборлолт	189.7	470.9	396.1	809.4	206.4	108.8%	338.5	71.9%
Газрын тос олборлолт	82.7	176.3	73.7	152.5	-8.9	-10.8%	-23.9	-13.5%
Металлын хүдэр олборлолт	394.5	812.9	378.3	825.7	-16.1	-4.1%	12.8	1.6%
Бусад ашигт малтмал олборлолт	6.6	11.8	7.9	16.3	1.3	20.2%	4.6	38.7%

Эх сурвалж: YCX

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2019 оны 2 дугаар сард **2.5** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **400.3 (19.3%)** тэрбум төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл **1.8** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **331.9 (22.5%)** тэрбум төгрөгөөр, үүнээс нүүрс олборлолт **338.5 (71.9%)** тэрбум төгрөгөөр, металлын хүдэр олборлолт **12.8 (1.6%)** тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн. Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлд Уул уурхай, олборлох салбар **73.0%**-ийг эзэлж байна.

II.3. Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн

тэрбум төгрөг

Салбар	2018		2019		Гад-дад	Өөрчлөлт			
	II	I-II	II	I-II		(4-2)=?, (4/2)=%	(5-3)=?, (5/3)=%		
1	2	3	4	5	6	7	8	9	10
Нийт дүн	992.1	2,354.9	1,200.2	2,774.5	2,035.4	208.1	21.0%	419.6	17.8%
Уул уурхай, олборлох аж үйлдвэр	627.9	1,634.8	768.4	1,962.8	1,792.4	140.6	22.4%	328.0	20.1%
Нүүрс олборлолт	234.3	617.7	283.3	758.3	691.3	49.1	21.0%	140.6	22.8%
Газрын тос олборлолт	67.1	151.3	68.4	140.0	140.0	1.3	1.9%	-11.3	-7.5%
Металлын хүдэр олборлолт	317.2	849.0	406.8	1,039.8	945.1	89.5	28.2%	190.7	22.5%
Бусад ашигт малтмал олборлолт	9.3	16.7	10.0	24.7	15.9	0.7	7.0%	0.7	47.8%

Эх сурвалж: YCX

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн 2019 оны 2 дугаар сард **2.8** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **419.6 (17.8%)** тэрбум төгрөгөөр, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн **2.0** их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс **328.0 (20.1%)** тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн **2.0** их наяд төгрөг буюу **73.4** хувь, уул уурхай, олборлох аж үйлдвэрийн салбар **1.8** их наяд төгрөг буюу **64.6** хувийг тус тус гадаад зах зээлд тус тус борлуулсан байна.

III. ГАДААД ХУДАЛДАА

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2019 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр **1.9** тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс **23.4** хувиар буюу **366.7** сая ам.доллараар өссөн байна. Экспорт импортоос давамгайлж экспорт, импортын зөрүү **256.1** сая ам.доллараар эерэг гарсан байна.

III.1. Экспорт

Экспорт **1.1** тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс **255.2** сая ам.доллараар буюу **30.4** хувиар өссөн байна.

Эрдэс бүтээгдэхүүний экспорт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 I-II		2019 I-II		Өөрчлөлт			
			Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Үнийн дүн	Тоо хэмжээ	Хувь	Үнийн дүн	Хувь
1	Чулуун нүүрс	сая тн / сая \$	3.1	242.3	4.0	332.4	0.9	27.8%	90.2	37.2%
2	Зэсийн хүдэр, баяжмал	мян.тн / сая \$	205.1	274.6	229.4	309.1	24.3	11.8%	34.4	12.5%
3	Боловсруулаагүй нефть	мян.бар / сая \$	1,009.9	62.6	1,011.4	53.0	1.5	0.1%	-9.7	-15.4%
4	Төмрийн хүдэр, баяжмал	мян.тн / сая \$	932.4	39.6	1,181.4	52.2	249.1	26.7%	12.6	31.8%
5	Жонш	мян.тн / сая \$	49.5	15.7	69.2	23.4	19.7	39.9%	7.7	49.1%
6	Цайрын хүдэр, баяжмал	мян.тн / сая \$	21.1	37.2	24.6	34.4	3.5	16.5%	-2.7	-7.3%
7	Молибдены хүдэр, баяжмал	тн / сая \$	949.1	6.1	935.9	8.2	-13.2	-1.4%	2.1	34.8%
8	Хар тугалганы хүдэр, баяжмал	мян.тн / сая \$	2.5	6.6	3.0	7.0	557.2	22.5%	0.4	5.8%
9	Гянтболдын хүдэр, баяжмал	тн / сая \$	50.9	0.7	45.0	0.5	-5.9	-11.6%	-0.2	-29.2%
10	Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт	кг / сая \$	1,696.0	72.2	4,665.2	195.9	2,969.2	175.1%	123.7	171.4%

Эх сурвалж: ГЕГ

III.2. Импорт

Импорт **837.5** сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеийнхээс **111.5** сая ам.доллараар буюу **15.4** хувиар өссөн байна.